

Living the Lotus 12

Buddhism in Everyday Life

2025
VOL. 243



РКК, Олон улсын буддын нийгэмлэг (IBC)

«Нэгэн сэтгэлээр» уриатай Япон дахь гадаад иргэдийн буддын нийгэмлэг



Гишүүний гэрт



Токио хотын
музей үзсэн нь



Хооза



Икэбана клуб



Япон хэлний
сургалт

Living the Lotus Vol. 243 (2025.12)

Ахлах редактор: Акагава Кэйичи
Орчуулсан: Ж.Гэрэлтуяа
Эхийг хянасан: Ш.Зоригмаа
Хэвлэсэн: Рисшо Косей Кай, ОУХ
Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada,
Suginami-ku, Tokyo 166-8537 Japan
TEL: +81-3-5341-1124
FAX: +81-3-5341-1224
Email: living.the.lotus.rk-international@
kosei-kai.or.jp

Рисшо Косей Кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо, хамтран үндэслэгч Наганума Мёкоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Лянхуан Гурамсан Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Бид тус байгууллагын ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн энх тайвны үйлсэд хувь нэмэр оруулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнтэй амьдралыг туулцаая гэсэн хүсэл шингэсэн билээ. Энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Найрал хөгжим хамтын хүчээр бий болдог-2 “Чадвар ба үүргээ ухамсарлах нь”

Рисшо Косей Кай, ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Бид хэдийн байгалийн зохицол дунд оршдог

Цүкүба их сургуулийн хүндэт профессор Мүраками Казүо гуай “Биеийн эс өөрөө ажиллангаа бусад эсээ дэмжиж байдаг учраас эд эрхтэний үйл ажиллагаа явагддаг. Эд эрхтэн ч гэсэн өөрөө ажиллангаа бусад эд эрхтэнээ дэмжиж байдаг” гэж хэлсэн. Өмнөх сарын дугаарт дэлхий ертөнцийн өнөөгийн байдлыг харахад ямар сэтгэл хүмүүс, улс орны эв найрамдлыг бусниулдаг талаар, яг одоо бидэнд юу хамгийн чухал байгаа талаар дурдсан. Хүний биеийн эс хүртэл байгалиасаа бие биенээ дэмжиж, өөр хоорондоо зохицон оршдог гээд бодохоор хүмүүс бид угийн бусадтай нэгдэн нийцэх чадвартай гэсэн үг. Энэ чадвараа ашиглах юм бол логикийн хувьд “дэлхийн энх тайван боломжгүй зүйл биш” гэж хэлж болохоор байна. Гэхдээ энэ мэдээж тийм амар биш зүйл гэдгийг бүгд мэдэж байгаа.

Хэдий тийм ч гэсэн хүн бүхэн өдөр бүр талархсан сэтгэлтэй, гэр бүлийнхэнтэйгээ эв түнжинтэй амьдарч, тэр нь цаашлаад хөрш айлуудад эерэгээр нөлөөлөн эргэн тойрны хүмүүс сайхан харилцаатай болох эсвэл нийгэм нь энх тайван, ард иргэд нь сэтгэл тайван амьдардаг улс гэдгээрээ бусад улс орны итгэлийг хүлээсэн улс болох юм бол хүн төрөлхтний эв нэгдэл, дэлхийн энх тайван биелэгдэшгүй мөрөөдөл биш гэж би боддог юм.

Би Күнзийн “Биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө засаж энх тайвныг бүтээх” хэмээх үгнээс эш татаж, ялангуяа “өрх гэрээ засах” гэдгийг чухалчлах хэрэгтэй гэж хэлж байсан нь гэр бүл гэдэг нийгмийн эд эс эрүүл байж гэмээнэ дэлхийн энх тайван бий болно гэж боддог учраас тэр билээ. Гэр бүл бол “хүн



бэлдэх үндэс суурь” гэж хэлсэн маань нь ч гэсэн хүнлэг хүнийг өгсөн хүмүүжүүлэхэд гэр бүлийн зөв сайхан харилцаа хамгаас чухал, тийм гэр бүлд өссөн хүмүүс л дэлхийн энх тайвныг бүтээнэ гэдэгт итгэдэг учраас тэр билээ.

“Эх орноо хайрлах сэтгэл” гэж юу вэ?

Та бүхэн гэр бүл, амьдарч буй дүүрэг, сургууль, ажил дээрээ ямар үүрэг хүлээдэг вэ? Бусдад ямар тус хүргэж байгаа гэж өөрийгөө боддог вэ? Ингэж асууж байгаагийн учир нь эв нэгдлийг бий болгох хамгийн чухал зүйл бол саяны хүний биеийн эд эс шиг хүн бүр өөр өөрийн үүргээ биелүүлж, бусдын төлөө гэсэн сэтгэлтэй байх явдал болохоор тэр юм.

Эргэн тойрныхоо хүнтэй эвтэй байж, уянгалаг найрал хөгжим тоглохын тулд юуны түрүүнд өөрийнхөө чаддаг зүйл, үүрэг хариуцлагыг ухамсарлаж, түүнийгээ чадахаараа хийх. Дараа нь бусад хүмүүсийн яриа, сэтгэлийг чих тавин анхааралтай сонсох хэрэгтэй. Өөрийнхөө чадварыг бүрэн дүүрэн гаргахын тулд найрал хөгжмийн нэг гишүүн шиг бусдынхаа дуу хоолой, сэтгэлийг сонсохын зэрэгцээ өөрийнхөө дуу хоолойгоо ч гэсэн хэт чанга байна уу, өнгө нь таарч байна уу гэж сайтар чагнах чухал. Ингэснээр хүний сэтгэлийг тайвшруулах уянгалаг сайхан аялгуу гарна.

Физикийн онолын эрдэмтэн Сажи Харүо гуайн сургасан сайхан нийгмийг бүтээх “баярлалаа, та бүхний ачаар, хэн хэн нь анхаарч хичээе, уучлаарай” гэдэг үгнүүдийг өдөр тутамдаа байнга хэрэглэж байвал сайхан харилцаа удаан үргэлжилдэг ажээ.

Мөн Үүсгэн байгуулагч “Улс орноо үнэн сэтгэлээсээ хайрлаж чаддаггүй үндэстнийг бусад орны хүмүүс ойлгоно гэж байхгүй” гэж хэлсэн. Бусад улс оронтой эв найрамдалтай байхын тулд өөрийн улс орноо хайрлах сэтгэл хамгаас чухал гэсэн үг. Гэхдээ энэ нь дайн дажин өдөөдөг үндсэрхэг үзэл, дээрэнгүй үзэл огт биш ба эх орноо хайрлахын эрхэнд жинхэнэ утгаараа энх тайван улс болгох юмсан гэсэн сэтгэл юм. Амар тайван улс орныг үр хойчдоо үлдээе гэсэн сэтгэл, бусад улсын хүмүүс ч гэсэн адилхан улс орноо хайрлаж байгаа болохоор дайн дажин хийхгүй нэгнээ дэмжье гэсэн сэтгэл болно. Энэ нь бусдыг хүндэлж буй хэрэг ба зарим үед өөртөө дүгнэлт хийж, өөрөөсөө ичиж даруу төлөв байх нь өсөн дэвших хөдөлгүүр болдог.

Ийнхүү улс орноо хайрлаж, бусдыг хүндэлж хүн шиг амьдарч, өөртөө хийгээд сургаал номд түшиглэж, булаалдах бус хуваалцаж амьдрахын сайхныг дэлхийд түгээж, үүнийгээ ирээдүй хойчдоо даатган үлдээх тийм хүмүүс байх сан гэж бодож байна.

Косей сэтгүүл, 12-р сарын дугаараас



Талархал

Акагава Кэйичи

Та бүхэн сайн байцгаана уу?

Энэ жил харвасан сум шиг өнгөрч, удахгүй он дуусах гэж байна. Та бүхэн 12-р сарыг хэрхэн угтсан бэ?

Энэ сар ч гэсэн Нивано ерөнхийлөгч гүнзгий сэтгэгдэл төрүүлэм сургаал айлдсан байна. Дэлхийн энх тайван ганц хүний хүчээр бий болох боломжгүй ба хүн бүр эв нэгдлийг ухамсарлаж, өөрт оногдсон үүргийг хэрэгжүүлснээр бий болно гэж сургажээ. Энэ талаар 40 жилийн өмнө Үүсгэн байгуулагч “Дэлхийн энх тайвныг бүтээнэ гэдэг бодсоноос амархан зүйл. Хүн бүр энх тайвны төлөө гэсэн ухамсартай, бусадтай эв эетэй байвал шүү дээ” гэж хэлсэн байдаг. Нивано ерөнхийлөгч сар бүр олон зүйлийг ойлгож ухааруулж, бидний ухамсрыг сэргээж байсанд туйлын их талархаж байна.

Мөн тэрээр эв нэгдлийн талаар хүний биеийн эд эстэй холбон тайлбарласан. Үүнийг сонсоод ерөнхийлөгчийн байнга хэлдэг буддын Зэн урсгалын Доогэн багштаны “бусдын төлөө” гэдэг үг санаанд орлоо. “Өөрийгөө таних гэдэг өөрийгөө мартах болой” гэдэг үг шиг хүн өөрийгөө мартах үед би ба бусад гэсэн хил хязгаар үгүй болж “бусдын төлөө” гэсэн сэтгэлтэй болдог. Ингэснээр өөрөө хожиж, бусдыг хохироох эсвэл бусдад автагдан өөрийгөө алдах явдал гарахгүй. Тиймээс би цаашид ч гэсэн жинхэнэ би бол бусдын төлөө орших би гэдгийг санаж амьдрах болно.

Миний бие энэ жилийн хүний нөөцийн шилжилтээр олон улсын хэлтсийн даргын үүргээс бууж, зүүн Азийн Шри-Ланка болон Бангладеш салбарын тэргүүний үүргийг хүлээж авлаа. Үүнтэй холбогдуулан шинэ даргыг танилцуулж байна. Токио хотын баруун бүсийн Итабаши салбарын тэргүүнээр ажиллаж байсан Маэда Такаши гуай олон улсын хэлтсийн даргын үүргийг хүлээж авлаа. Тэрээр удирдах төвийн удирдах алба, салбар нийгэмлэгт олон жил ажилласан туршлагатай тул та бүхнийг итгэж найдаж хамтран ажиллахыг хүсэж байна.

Энэхүү даргын булан маань ийнхүү төгсөж байгаад жаахан харамсаж байна. Таван жилийн турш халуун дулаанаар дэмжиж байсан Living the Lotus сэтгүүлийн уншигч та бүхэндээ гүнээ талархал илэрхийлье.

Миний бие сургаал дэлгэрүүлэгч хүний хувиар Үүсгэн байгуулагч, Нивано ерөнхийлөгчийн сургасан эгэл сүсэгтэн хүний зам мөрийг яаралгүй гэхдээ амрахгүй түгээн дэлгэрүүлэх болно.

Уншигч та бүхэн цаашид ч гэсэн тус даргын булангаа уншиж дэмжиж байгаарай.




Акагава дарга шинэ Маэда даргын хамт

Rissho Kosei-kai International


Make Every Encounter Matter



🌸 A Global Buddhist Movement 🌸



Information about
local Dharma centers



facebook



X



✉ We welcome comments on our newsletter Living the Lotus: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp